



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2020 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 02

Арвайхээр

**Г Өвөлжилтийн бэлтгэлийг хангах, цаг үеийн
ажлыг эрчимжүүлэх тухай**

Энэ жил манай аймгийн хувьд зуншлага оройтож болсон, өөрийн аймгийн болон өөр аймгийн сумдад отор нүүдэл ихээр хийж байгаа, бэлчээрийн даац багтаамж 3-6 дахин хэтэрсэн, байгалын хадлан тэжээл бэлтгэх нөхцөл бололцоо муу байгаа зэргээс шалтгаалан 2020-2021 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын байдал хүндрэх төлөвтэй байгаа тул болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/338 дугаар захирамжийн биелэлтийг газар дээр нь үзэж, үнэлэлт дүгнэлт өгч, зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг авч, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Сум багийн Засаг дарга нарт

1.1.Хөдөө аж ахуйн 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээг сум бүр өөрийн онцлог байдалд тохируулан үе шаттай хэрэгжүүлж, өвөлжилтийн бэлтгэлийг 10 дугаар сарын 01-ны дотор бүрэн хангах, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

1.2.Өөрийн сумаас хадлан тэжээл бэлтгэх бололцоогүй сумд хадлангийн нөөц талбай бүхий сум, аймгуудтай гэрээ, хэлцэл аймгийн Хөдөө аж ахуйн газраар дамжуулан хийж өвс, тэжээлийн нөөцөө нэмэгдүүлэх, бүрдүүлэх, малын хужир шүү бэлтгэж өвс, тэжээлээр солилцох зэргээр тэжээлийн нөөцөө нэмэгдүүлэх бүхий л арга хэмжээг авч ажиллах.

1.3. Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/338 дугаар захирамжийн дагуу сум, малчдын түвшинд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн хуваарийг тогтоон өгсөн. /хуваарийг хавсаргав/ Иймд 08 дугаар сарын 05-аас эхлэн хадлан тэжээл бэлтгэх бололцоотой бүх аж ахуй нэгж, иргэд, малчдын хүчийг хадлан тэжээл бэлтгэх ажилд чиглүүлэн ажиллах даалгаварыг 10 дугаар сарын 01-ны дотор биелүүлэх арга хэмжээг авч ажиллах.

1.4.Хадлан тэжээлийн мэдээг долоо хоног бүр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд мэдээлж байх тул сумд мэдээг 2020 оны 08 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн 3 дахь өдөр бүр Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлж байх.

011200003

1.5. Шаардлагатай тохиолдолд цаг алдалгүй өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг (худалдан авах) холбогдох хууль журмын хүрээнд шууд худалдан авалт хийж, иргэн аж ахуйн нэгтжтэй гэрээ байгуулан ажиллах.

1.6. Бэлчээрийн даац багтаамж хүрэлцээгүй болсон, газрын гарц тааруу байгаа үед отор нүүдэл хийх бүс нутгийг тогтоож, холбогдох сумдтай гэрээ хэлцэл байгуулан, отор нүүдэл хийх өрх, малын тоог тогтоож, тухайн малчин өрхийн өвөлжих газрыг тодорхойлон тогтоож өгсөн байх.

1.7. Сум бүрт тогтоож өгсөн (аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 96 дугаар тогтоол) сум дундын отрын бүс нутгийн бэлчээрийг хяналтандаа авч, цаг хүндэрсэн үед отроор мал оруулах боломж нөхцлийг бүрдүүлэх.

1.8. Өөрийн аймгийн өөр сумаас оторлож байгаа малчдыг ямар нэгэн татвар татаас нэхэж, нутаг ус зааж хөөж туухгүй байх.

1.8. Өөрийн аймгийн өөр сумаас болон өөр аймгаас отор нүүдэл хийж байгаа малчин өрхөд сум орон нутгийн зүгээс төрийн үйлчилгээ тогтмол үзүүлж байх.

1.9. Малын тоо толгойн өсөлтөөс бэлчээрийн даац багтаамж хэтэрч байгаа тул сумын удирдлагууд, малчид аймаг, нийслэлийн нөөцөд мал мах бэлтгэх ажлыг урьд жилүүдээс илүү хэмжээтэй, эрчимтэй бэлтгэх арга хэмжээг авч ажиллах.

1.10. Малчдын хувийн бэлтгэлийг хангахад анхаарч, тэдэнд цаг агаарын мэдээ, мэдээллийг тухай бүрт авч байх боломжийг бүрдүүлэх, цаг хүндэрсэн үед өргөн хэрэглээний бараа, төрийн болон хүн эмнэлэгийн үйлчилгээгээр гачигдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах.

1.11. Улсын төсөв болон төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар шинээр гаргаж буй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж буй аж ахуй нэгжийн ажлын явц, чанарт хяналт тавьж, гаргаж дууссан нөхцөлд орон нутгийн өмчид бүртгэн авч, малчдыг бүлэг, хоршоо, нөхөрлөлд албан ёсоор гэрээгээр эзэмшүүлэх зэргээр хүн малын усан хангамжийн нэмэгдүүлэх.

1.12. Өвөлжилтийн арга хэмжээ болон "COVID-19" цар тахлын үед орон нутагт зохиогддог баяр наадам олон нийтийн арга хэмжээг зохион байгуулахгүй байх.

1.13. Малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөцийн мэдээг малчин өрхийн нэрээр нарийвчлан ирүүлэх.

1.14. Өөрийн аймгийн өөр суманд болон гадны аймагт оторлох малчин өрхөд байгаа жирэмсэн болон өндөр настан, 0-5 хүртэлх насны хүүхдийн судалгааг ирүүлэх.

1.15. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдлыг хангах, цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

Хоёр: Малчид болон мал бүхий иргэдэд зөвлөх нь

2.1. Мал сүргийг отроор таргалуулан дундаас дээш тарга хүч авахуулах ажлыг зохион байгуулж, мал таргалуулах отор нүүдлийг 11 дүгээр сар хүртэл хийх.

2.2.Бог малын төлийг 08 дугаар сарын 05-ны дотор эхээс ялгаж, эх, төлийг тарга хүч авахуулах.

2.3.Малдаа үзлэг хийж тухайн жилийн хүйтний улирлын цаг агаарын төлөв, өөрсдийн бололцоонд тулгуурлан эдийн засгийн эргэлтэнд оруулах малын тоог тогтоож, отор хийх малдаа тарга хүч авахуулсан ажлын дүнг малчин бүр гаргаж, малаа нас хүйсээр нь тарга хүчээр нь ангилан өвөлжилтэнд бэлтгэх.

2.4.Дунд, дундаас доош тарга хүчтэй нас хөгширсөн заазлах малыг өвлөөс өмнө бүрэн борлуулах бэлтгэлийг хангасан байх.

2.5.Малчин бүр өөрсдийн өвөлжөө, хаваржааны засвар үйлчилгээг чанартай сайн хийж хашаа хорооны хөрзөнг сийрүүлж, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, өтөг бууцыг хүрэлцэхүйц хэмжээгээр нөөцлөх.


2.6.Малчн бүр өвөлжилтийн хувийн бэлтгэлээ сайтар базаан дулаан хувцас, түлээ нүүрс, хоол хүнсээ хүрэлцэхүйц хэмжээгээр нөөцлөх.

2.7.Орон нутгийхаа онцлог, өөрсдийн боломжинд тулгуурлан мал тэжээж болохуйц халтар арвай, хөх хомоол, таана хөмүүл, халгай, лууль, сүрэл, төмс хүнсний ногооны иш, навч, зэргийг бэлтгэн гар тэжээл болгон ашиглах.

2.8.Хээлтүүлгийг цаг агаарын төлөв, малын тарга, хүн хүчний нөөцөд тулгуурлан бодлоготой зохион байгуулж, хуц ухныг өвөлд ялган тэжээх бэлтгэл ажлыг хангах.

2.9.Сүү орлох тэжээлийг төллөх малын 20 хувьд хүрэлцэхээр бэлтгэх

Энэхүү албан даалгаварыг хэрэгжилтэнд байнга хяналт тавьж, биелэлтийн явц болон өвөлжилтийн бэлтгэл хүлээн авсан дүнг Засаг дарын зөвлөлд танилцуулахыг айгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Цэдэнбалжирт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  О.БАТЖАРГАЛ